

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

2019



АГУУЛГА

Дэс дугаар	Агуулга, бүлгийн нэр	Хуудасны дугаар
1	1. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	3
2	2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	4
3	2.1 Төсвийн шууд захирагчийн тайлан	5
4	2.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан	9
5	2.3 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан	10
6	2.4 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
7	3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ	12
8	3.1 “Аймгийн орон нутгийн төсвийн татварын бус орлого бүрдүүлэх үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит	13
9	3.2 Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг /ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар/	13
10	4. НИЙЦЛИЙН АУДИТ	14
11	4.1 “Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт” сэдэвт нийцлийн аудит	14
12	4.2 “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудит	15
13	4.3 “Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр үйл ажиллагаа нь газрын тухай хуульд нийцсэн эсэх” сэдэвт нийцлийн аудит	15
14	5. ИТХ-ЫН ЗАХИАЛГА, ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ	16
15	5.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудит	16
16	5.2 Орон нутгийн өмчит компаниудын худалдан авах ажиллагааны үр дүн гүйцэтгэлийн аудит	16
17	6. ДОТООД АЖИЛ	17
18	6.1 Дотоод сургалт	17
19	6.2 Бусад байгууллагаас авах сургалт	17
20	6.3 Архив, бичиг хэрэг	18
21	6.4 Ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа	18
22	6.5 Дотоод зохион байгуулалтын бусад асуудал	18
23	7. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	19
24	8. ДҮГНЭЛТ, САНАЛ	19
25	8.1 Дүгнэлт	19
26	8.2 Санал	20



Товчилсон үгийн тайлбар

ҮАГ	Үндэсний аудитын газар
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ЕБ	Ерөнхий боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НААҮОНӨХХК	Нийтийн аж ахуйн үйлчилгээ, орон нутгийн өмчийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨ	Орон нутгийн өмчит
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХАК	Хувийн аудитын компани
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШГ	Шууд гэрээ
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ШШГХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсэг
ЭМТ	Эрүүл мэндийн төв


1 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудиторын дэвшүүлсэн “Аудитыг баримтжуулах бодлого, арга зүйг боловсронгуй болгож төлөвшүүлэх” зорилтын хүрээнд 2019 онд нийт 40 хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Монгол Улсын Ерөнхий аудитор тус байгууллагын бүтэц орон тоог 11 байхаар баталсан бөгөөд 2019 оны эхний хагас жилийн байдлаар санхүү, гүйцэтгэл, нийцлийн алба болон дэмжих баг гэсэн бүтцээр, нийт 10 орон тоотой, нийт 665 хүн/өдөр, 1540 илүү цаг ажиллалаа.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 4 гүйцэтгэлийн аудит, 3 нийцлийн аудит, улс, орон нутаг төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн 217 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт 108498,2 сая төгрөгийн 626 алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 72403,6 сая төгрөгийн 120 алдааг залруулж, 167,61 сая төгрөгийн зөрчилд 71 төлбөрийн акт тогтоож, 9360,64 сая төгрөгийн зөрчилд 83 албан шаардлага хүргүүлж, 26547,94 сая төгрөгийн зөрчилд 338 зөвлөмж, 18,4 сая төгрөгийн зөрчилд 13 хариуцлага тооцох санал хүргүүлж, 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.



Тайлант хугацаанд төлбөрийн акт, албан шаардлагыг хангуулж, улс, орон нутгийн төсөвт 257,4 сая төгрөгийг төвлөрүүлээ.

2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 217 байгууллага, тусгай сангуудыг аудитад хамруулахаас 41,5 хувь буюу 90 тайланд Төрийн аудитын газар, 58,5 хувь буюу 127 тайланд ХАК-иуд дүгнэлт гаргаж, түүвэрт хамруулсан байна.



Монгол улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/191 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг үндэслэн хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулж Сайн аудит ХХК, Мөнгө нөөц аудит ХХК, Ингүүмэл жаргалант аудит ХХК-иудтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллалаа.


Санхүүгийн тайлангийн аудитаар 125 шууд захирагч, 14 төвлөрүүлэн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит 6 аж ахуйн нэгж, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, нийт 150 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 67 шууд захирагч болон ЗГТС-ийн тайланг түүвэрт хамрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 101752,8 сая төгрөгийн 566 алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 72403,6 сая төгрөгийн 120 алдааг залруулж, 166,2 сая төгрөгийн зөрчилд 67 төлбөрийн акт тогтоож, 6768,7 сая төгрөгийн зөрчилд 61 албан шаардлага хүргүүлж, 22395,9 сая төгрөгийн зөрчилд 304 зөвлөмж, 18,4 сая төгрөгийн зөрчилд 13 хариуцлага тооцох санал хүргүүлж, 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг авч үзэхэд 20,6 сая төгрөгийн 21 төлбөрийн акт барагдаж биелэлт 31,3 хувьтай, 195,0 сая төгрөгийн 19 албан шаардлага хэрэгжиж биелэлт 29,5 хувьтай, 135,2 сая төгрөгийн 39 зөвлөмж хэрэгжиж биелэлт 11,2 хувийн хэрэгжилттэй, нийт акт, албан шаардлага, зөвлөмжийн 75,2 хувь нь хэрэгжих хугацаа нь болоогүй байна.

2.1 Төсвийн шууд захирагчийн тайлан

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 125 төсвийн **Шууд захирагчийн** санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 38 санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа. Тус аудитаар 99 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 21 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 2 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгч, 3 байгууллагад санал дүгнэлт өгөхөөс татгалзлаа.



Санхүүгийн тайлангийн аудитаар оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчлүүдийн улмаас “Хязгаарлалттай”, “Сөрөг”, “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт өгсөн.

1. **Замын Үүд сумын ИТХурал:** Сумын ИТХ-ын даргын нөөц хөрөнгийг зарцуулах журам, Сумын ИТХ-ын төлөөлөгчид тойрогтоо ажиллахад хөрөнгө зарцуулах журам гаргасан ба Хурлын даргын нөөц хөрөнгөөс ИТХ-ын төлөөлөгчдийн тойрогт ажиллах зардал, оюутан сурагчдын сургалтын төлбөр болон биеийн тамирын уралдаан тэмцээнд оролцогчдод дэмжлэг, зочид төлөөлөгчдийг хүлээн авах зардал, байгууллагуудад хөрөнгийн дэмжлэг, шагнал урамшуулал, шинэ жилийн баяр зэрэгт нийт 59951.7 мянган төгрөгийн зардал гаргаж төсвийг үрэлгэн зарцуулсан.
2. **Сайншанд сумын ЗДТГазар:** Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 59,851.7 мянган төгрөгийг зарцуулахдаа Засаг даргын зөвлөлийн гишүүдийн хурлын шийдвэргүй захирамж гарган зарцуулсан, 27,543.9 мянган төгрөгийн хөрөнгийн шинжтэй худалдан авалт хийсэн, 31,109.0 мянган төгрөгийн нөөц бүрдүүлээгүй журам зөрчсөн.
3. **Сайншанд сумын ИТХурал:** Тайлант жилд батлагдсан бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлын 21,700.0 мянган төгрөгийг зарцуулахдаа шууд худалдан авалт хийсэн байна. Шууд худалдан авсан ажил гүйлгээний 43 хувийг ИТХ-ийн гишүүдийн үйл ажиллагааг сурталчлахад чиглэгдсэн зардалд, хурлын хоолны зардалд 25 хувь буюу 5208,6 мянган төгрөгийг, дэмжлэг шагналд 26 хувь буюу 5403,0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.



4. *Сайншанд сумын ЗААлба*: Орон нутгийн төсвийн хөрөнгөөс нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан 20370,0 мянган төгрөгийн шатахууны төлбөрийг нотлох баримтгүйгээр олгосон. Мөн 2012 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр аймгийн ИТХ-аар баталсан Замын Үүд, Сайншанд сумдын төвд нийтийн тээврийн хэрэгслээр зорчих ахмад настан, ХБИргэд, оюутан, сурагчдыг хөнгөлөлттэй нөхцөлөөр тээвэрлэх журам"-ыг үндэслэн олгож байгаа санхүүжилт зорилтот бүлэгт хүрч байгаа эсэхийг хянах ажил орхигдсон, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа МУ-ын ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдөөгүй нь аймгийн ИТХ-аар батлагдсан журмыг зөрчсөн.
5. *Хөвсгөл ЗДТГазар*: 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 6427,7 мянган төгрөгийн авлагын , 3903,5 мянган төгрөгийн өглөгийн тус тус үлдэгдэлтэй боловч тооцоо нийлж баталгаажуулаагүй.
6. *Алтанширээ ЭМТөв*: Сумын ЭМТ-ийн удирдлага нь 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуулинд заасан хугацаанаас хоцроож ирүүлсэн.
7. *Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар*: Санхүүгийн тайлангийн бараа материалын дансанд бүртгэлтэй 71732,5 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг хагас жил болон жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахаас өмнө тоолж, баталгаажуулаагүй.
8. *Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль*: Тайлант оны батлагдсан төсвийн хуваарьт түлээ нүүрс, хоол, эд хогшил худалдан авах, урсгал засварын зардалд нийт 42908,2 мянган төгрөг батлагдсан байх ба тус төсвийг зарцуулахдаа МУ-ын ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", Засгийн газрын 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 9.1.2-т "Тухайн жилд төсвийн байгууллагын нийлүүлэгчтэй байгуулсан худалдан авах гэрээний захиалгын үнийн нийт дүн нь жилийн батлагдсан төсвийн хүрээнд байна" гэсэн заалтуудыг зөрчин худалдан авах ажиллагааны төлөвлөгөө хийгээгүй, худалдан авах ажиллагааг нийтэд зарлаагүй, харьцуулалтын арга хэрэглэж гүйцэтгэгчийг сонгохгүйгээр шууд худалдан авалт хийсэн.
9. *Айраг сумын ЕБСургууль*: 2018 онд тус сургуулийн Үдийн цай хөтөлбөрийн хүрээнд хоолны зардалд 21534,9 мянган төгрөгийн бараа худалдан авахаар захирлын 2018.08.29-ний өдрийн А/30 тоот тушаалаар үнэлгээний хороо байгуулж, 2018.08.30-ны өдөр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар тов гаргасан байх боловч шалгаруулалтын талаар үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, боловсруулсан тендерийн баримт бичиг, сонгон шалгаруулалт хийсэн үнэлгээний хуудас болон бусад тэмдэглэл байхгүй байгаа нь МУ-ын ТБОНӨХБАҮХАТухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй.
10. *Замын Үүд сумын ЕБ-ын 2 дугаар сургууль*: 2018 оны үйл ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг төвлөрүүлэхгүй, Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Идэр Өлзий дархан уул ХХК-ний харилцах дансанд 3249,2 мянган төгрөгийг төсвийн тэтгэмж урамшууллын зардлаас, аймгийн НДХ-ийн дансанд төсвийн ажил олгогчоос төлөх НДШ болон цалингийн зардлаас 3555,3 мянган төгрөгийг, Чандмань бадрал ХХК-ний дансанд төсвийн түлш халаалтын зардлаас 4998,5 мянган төгрөгийг тус тус шилжүүлэн санхүүгийн тайланд авлагаар тусгаж бүртгэсэн, мөн төсвийн хичээл сургалт үйлдвэрлэлийн зардал 22820,9 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 100 хувь зарцуулахдаа төсвийн шууд захирагч нь МУ-ын ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8.1, Засгийн газрын 129 дугаар тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтийг үндэслэхгүйгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.



11. *Замын Үүд сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль*: 2018 оны батлагдсан төсвийн хоол, урсгал зардал, хичээл сургалт, үйлдвэрлэлийн гэсэн 3 төрлийн зардлаас 85745,4 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн, 6267,2 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг нотлох баримтгүйгээр төсөвт байгууллага болон аж ахуй нэгж, байгууллагын дансанд шилжүүлсэн, 2017 онд үүссэн 10577,1 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй.
12. *Өргөн сумын ЕБСургууль*: Тус байгууллага нь Эвийн гэрээ ХХК-иар дотуур байрны бохирын шугамын засварын ажил гүйцэтгүүлэхээр 2018 оны 11 дүгээр сард гэрээ байгуулсан ба гэрээнд заасны дагуу урьдчилгаа төлбөрт гэрээний үнийн дүнгийн 50 хувийг шилжүүлж, ажил гүйцэтгэж дууссаны дараа үлдэгдэл төлбөрийг шилжүүлэх байсан боловч ажил хүлээн авах комиссын дүгнэлт гараагүй байхад төлбөрийг бүрэн шилжүүлж, 19000,0 мянган төгрөгийн авлага үүсгэж тайлагнасан, тайлант хугацаанд урсгал засварын зардал 30343,3 мянган төгрөг, хичээл сургалт, үйлдвэрлэлийн зардал 18614,2 мянган төгрөгөөр батлагдаж, нийт 48957,5 мянган төгрөгийг зарцуулахдаа шууд худалдан авалт хийсэн.
13. *Дэлгэрэх сумын ЕБСургууль*: Тайлант хугацаанд түлш халаалтын зардалд батлагдсан 63991,8 мянган төгрөгийг зарцуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдөөгүй, www.tender.gov.mn сайтад байршуулж нийтэд мэдээлээгүй, нээлттэй тендер зарлахгүйгээр иргэн Б.Магсармаа, Р.Эрдэнэболд, Г.Мөнхдөл, Ди Ай Би Би Эй ХХК-тай гэрээ байгуулан шууд худалдан авалт хийсэн, ажил гүйцэтгэх гэрээг дүгнээгүй, шалтгаан тодорхой бус байхад дараагийн бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулсан, батлагдсан төсвийн хичээл сургалт үйлдвэрлэлийн зардлаас 17650,0 мянган төгрөгийг зарцуулахдаа харьцуулалтын аргыг хэрэглээгүй бэлтгэн нийлүүлэгчдээс шууд худалдан авалт хийж, төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй зарцуулах эрсдэлийг үүсгэсэн.
14. *Хөвсгөл сумын ЕБСургууль*: 2018 онд дотуур байрны сурагчдын хоолны зардал 28,9 сая төгрөг, үдийн цайны зардалд 133,0 сая төгрөг, түлээ нүүрс 13,6 мянган төгрөг, нийт 55,4 сая төгрөгийн худалдан авалт хийхдээ МУ-ын ТБОНӨХБАҮХАТХуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, тухайн жилийн төсвийн хэмнэлтээр 2019 оны зардлыг санхүүжүүлэхээр авлага үүсгэж, НДХэлтэс, Татварын хэлтэст нийт 348,2 мянган төгрөг шилжүүлэн зарцуулсан байна.
15. *Мандах сумын ЕБСургууль*: Тайлант хугацааны хоол, хүнсний зардалд батлагдсан 25,8 сая төгрөгийн санхүүжилтээр шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 24.4, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 9.1.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн, мөн ихэнх худалдан авалт нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Е баримт НХМ-ТМ-5-аар гүйлгээ хийгдээгүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 дахь заалтуудыг зөрчиж анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн байна.
16. *Эрдэнэ сумын ЕБСургууль*: Тайлант хугацааны тавилга, аж ахуйн эд хогшил, урсгал зардал, хичээл сургалт үйлдвэрлэлийн зардалд батлагдсан нийт 42,9 сая төгрөгөөр шууд худалдан авалт хийсэн, СИЗУ ХХК-тай засварын ажил гүйцэтгэхээр гэрээг 2018 оны 11 дүгээр сард байгуулж, гэрээнд заасны дагуу 2018/12/06-ны өдөр урьдчилгаа төлбөр болох 13,0 сая төгрөгийг шилжүүлэн, үлдэгдэл 12,5 сая төгрөгийг ажил хүлээлцсэн акт үйлдээгүй байхад авлага үүсгэн шилжүүлсэн, мөн НДХэлтэс, Татварын алба, Байгаль хамгаалах сангийн дансанд нийт 7,8 сая төгрөгийг шилжүүлэн авлага үүсгэн бүртгэж тайлагнасан, Боловсролын салбарын ажилтны цалин хөлсийг 2018 онд нэмэгдүүлэх асуудлаар хийсэн хэлэлцээрийн хүрээнд цалин хөлсний зөрүүг



- шийдвэрлэх зорилгоор төрийн үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох шийдвэрийг зөрчин төсвийн шууд захирагч 133,2 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон байна.
17. *Сайхандулаан сумын ЕБСургууль*: Багш, ажилчдын үр дүнг сар бүр үнэлээгүй, улиралд нэг удаа үнэлсэн, хувь хэмжээг зөрүүтэй тооцсоноос 1, 2, 4 дүгээр улирлуудад 12,7 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг илүү болон дутуу тооцож ажлын бодит үр дүнд үндэслэхгүйгээр хавтгайруулан олгосон, 2018 оны жилийн төсөвт батлагдсан 17,2 сая төгрөгийн хүүхдийн хоолны санхүүжилтийг ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчин үнийн харьцуулалт хийхгүйгээр шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн нь бусдад тэгш байдлыг олгоогүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулаагүй байна.
 18. *Хатанбулаг сумын ЕБСургууль*: Модоор урлахуй төсөл хийхэд шаардлагатай бараа авах зорилгоор төсвийн хичээл сургалт үйлдвэрлэлийн зардлаас 5,0 сая төгрөгийг иргэн Д.Одгэрэлийн ХААН банкин дахь харилцах данс руу 2018/11/28-ны өдөр урьдчилан шилжүүлсэн боловч тус онд төсөл бүрэн хэрэгжиж дуусаагүй шалтгаанаар бараа материалыг аваагүй, шилжүүлсэн мөнгийг авлагаар бүртгэж, тус иргэнтэй хүчин төгөлдөр бус тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан, БИ ЖИ ГЭРЭГЭ КАПИТАЛ ХХК-тай сургуулийн дотуур байрны халаалтын системийн засварын ажил гүйцэтгэх ХБ/ШГ/2018/01 тоот гэрээг байгуулсан байх ба гэрээний 3-т “,,, Мон лаа ХХК-ны хандиваар санхүүжүүлнэ” гэж заасан, тус компаниас хандивын санхүүжилтийг өгөөгүй байхад төсвийн урсгал засварын зардлаас тус ажлыг гүйцэтгээгүй Хатанбулаг хөгжлийн хөтөч ТББ-ын ХААН банкны 5371063722 дансанд 13,0 сая төгрөгийн санхүүжилтийг шилжүүлэн зарцуулсан байна.
 19. *Алтанширээ сумын ЕБСургууль*: Тайлант онд түлш халаалтын зардал 28,6 сая төгрөг, хоолны зардал 18,4 сая төгрөг, багаж техник хэрэгсэл 13,5 сая төгрөг, урсгал засвар 60,6 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн ба үүнээс урсгал засварын зардалд зарцуулсан 50,0 сая төгрөгийн худалдан авалтыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгэж тайлагнасан ба үлдэх 71,0 сая төгрөгийн худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.1.1, 33.1 дэх заалтуудын дагуу хийгээгүй байна.
 20. *Иххэт сумын Цэцэрлэг*: 2018 оны санхүүгийн тайлан гаргахаас өмнө буюу хуульд заасан хугацаанд бараа материалын тооллого хийж, тайлан тэнцэлд тусгаагүй байна.
 21. *Хатанбулаг сумын цэцэрлэг*: Санхүүгийн тайланд 2008 онд Шүүхээр шийдвэрлүүлсэн гэх боловч хариуцах эзэн нь тодорхойгүй 1,9 сая төгрөгийн авлагыг бүртгэж тайлагнасан байх ба авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүйгээс тус тус “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.
1. *Замын Үүд сумын ЭМТөө*: Нягтлан бодогчоор ажиллаж байсан А.Энхмаа нь албан тушаалаа урвуулан ашиглаж 2018 оны 03-07 дугаар саруудад өөрийн нэрийг 2-3 удаа цалингийн цэсэнд оруулан 8,7 сая төгрөгийн илүү цалин авсан, мөн байгууллагын төсвийн зардлаас өөрийн гар утасны зээлийн болон ярианы төлбөр нийт 1,0 сая төгрөгийг төсвөөс төлсөн байна.
 2. *Прокурорын газар*: Нягтлан бодогчоор ажиллаж байсан Ч.Туул нь 2018 оны 1, 2, 3, 4 саруудад Хаан банк, Голомт банк, Капитрон банкинд өгөх жагсаалтыг засч байгууллагын ажилчдын нэр дээр илүү дүнгээр өөрийн дансанд 8.5 сая төгрөгийг цалингийн сангаас гаргаж авсан байна. Ч.Туул нь үүнээс 0.8 сая төгрөгийг эргэн төлж, 2018 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайланд 7.7 сая төгрөгийн авлага үүсгэсэнд “Сөрөг” дүгнэлт өгсөн.



1. *Өргөн, Дэлгэрэх, Алтанширээ сумдын ЗДТГ-ууд нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “Төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх”, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Засгийн газар болон бусад байгууллагууд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргаж Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчиж 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлээ Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй нь цаг хугацааны хязгаарлалтад оруулж аудит хийх цар хүрээний хязгаарлалтыг бий болгосноор Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан.*

Төсвийн шууд захирагчийн тайланд 10629,8 сая төгрөгийн 397 алдаа зөрчил илрүүлж, 1722,2 сая төгрөгийн 67 алдааг аудитын явцад залруулж, 122,5 сая төгрөгийн зөрчилд 62 төлбөрийн акт тогтоож, 1054,1 сая төгрөгийн зөрчилд 47 албан шаардлага хүргүүлээ. Мөн төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналттай холбоотой 7712,6 сая төгрөгийн зөрчилд 217 зөвлөмж өгч, хязгаарлалттай санал дүгнэлт авсан 25 төсвийн шууд захирагчид хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлээ.

Тайлант хугацаанд 20,6 сая төгрөгийн акт барагдаж, 182,8 сая төгрөгийн албан шаардлага, 31 зөвлөмж хэрэгжиж, 184 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

2.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасан цаглабарт хугацаанд 14 төсвийн **Төвлөрүүлэн захирагчийн** тайланд дүгнэлт гаргаж, 10 тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 4 сумын төвлөрүүлэн захирагчийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг өгсөн.

1. *Алтанширээ сум ТТЗ:* Алтанширээ сумын ЗДТГазар нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй нь цаг хугацааны хязгаарлалтад оруулж “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан”, Эрүүл мэндийн төв нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, Ерөнхий боловсролын сургуулийн алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй.
2. *Замын Үүд сум ТТЗ:* төсвийн шууд захирагчийн 3 байгууллагын санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн, төвлөрүүлэн захирагч өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй, сумын төсвийн нийт орлогын төлөвлөгөө 30.9 сая төгрөгөөр тасарсан, аймагт төвлөрүүлэх орлогыг 28.9 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулахдаа МУ-ын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан аргачлалыг баримтлахгүйгээр 864.2 сая төгрөгийн зардал зарцуулсан байгаа нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, хэмжилт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй.



3. *Дэлгэрэх сум ТТЗ*: Дэлгэрэх сумын ЗДТГазар нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй нь цаг хугацааны хязгаарлалтад оруулж “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан”, Ерөнхий боловсролын сургуулийн алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй.
4. *Өргөн сум ТТЗ*: Сумын Засаг даргын Тамгын газар 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй нь цаг хугацааны хязгаарлалтад оруулж “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан”, Ерөнхий боловсролын сургуулийн алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байсан.

Аудитаар 3479,4 сая төгрөгийн 39 алдаа зөрчил илэрч, 2444,1 сая төгрөгийн 18 алдааг залруулж, 28,9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1.6 сая төгрөгийн 4 албан шаардлага, нийт 1004,8 сая төгрөгийн 14 зөвлөмжийг хүргүүллээ.

Тайлант хугацаанд 3,1 сая төгрөгийн албан шаардлага, 6 зөвлөмж хэрэгжиж, 7 зөвлөмжийн хэрэгжих хугацаа болоогүй байна.

2.3 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар Орон нутгийн өмчит 6 аж ахуйн нэгжийн тайланд дүгнэлт гаргаж, 4 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 2 санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн.

1. *Замын-Үүд сум дахь Чандмань бадрал ОНӨ ХХК*:
 - 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бэлэн мөнгө, юаний үлдэгдэл болох 7,3 сая төгрөг бэлнээр байхгүй дутагдсан,
 - Тухайн байгууллагад нийт 5 төрлийн, 20 нэгж авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл ашиглагдаж байгаа боловч Авто тээврийн үндэсний төвөөс авсан мэдээ болон тээврийн хэрэгслийн гэрчилгээнээс харахад 9 тээврийн хэрэгсэл тухайн байгууллагын нэр дээр бүртгэлтэй, 4 тээврийн хэрэгсэл нь Замын Үүд сумын НААҮОНӨХХК-нд, 1 тээврийн хэрэгсэл Замын-Үүд сумын ЗААпбанд бүртгэлтэй, зарим тээврийн хэрэгсэл нь тээврийн хэрэгслийн гэрчилгээгүй,
 - Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварт 828.5 мянган төгрөг төлсөн байгаа боловч 2018 онд татварын байгууллагад тайлан илгээгээгүй, тайлагнаагүй,
 - Нийт 1,0 сая төгрөгийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулан хийсэн.
 - Бэлэн мөнгийг их хэмжээгээр харилцах данснаас чекээр гарган авч шууд худалдан авалт хийсэн, бэлэн мөнгөний зарцуулалтад хяналт тавиагүй, тооцоог сар бүр бодоогүй, эд хариуцагч тайлангаа гаргаж сураагүй байдлаас үүдэн мөнгөн кассаар ажиллаж байсан албан тушаалтнуудын нийт 19,1 сая төгрөгийг дараа тооцооны авлагаар бүртгэж, тооцоог бодоогүй,
 - Тус байгууллага тайлант онд нийт 679,8 мянган төгрөгийг харилцах данснаас бэлнээр авч Эрээн хотоос бараа, түүхий эд материалыг шууд худалдан авалт хийж хууль зөрчсөн,



- Бэлэн мөнгөний зарцуулалтаас нийт 26,5 сая төгрөг дутагдал гаргасан байхад хяналт тавьж ажиллаагүй, бэлэн мөнгө хадгалах, хамгаалах аюулгүй ажиллагааны нөхцөл бүрдээгүй,
- Кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээний тайланг хийж хэвшээгүй, хариуцсан нягтлан бодогч бэлэн мөнгөний ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахдаа буруу бичилт хийсэн, анхан шатны нотлох баримтад Е баримт хавсаргаагүй, хүчин төгөлдөр бус баримтууд хавсаргасан,
- Бэлэн мөнгөөр бараа бүтээгдэхүүн авахдаа үнийн судалгаа хийдэггүй, захиалгын хуудсыг тодорхой бичээгүй, баталгаажуулаагүй, нэгжийн өртгийг хянах боломжгүй,
- Бэлэн мөнгөөрх худалдан авалтад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, мөнгөн хөрөнгө ашиглах завших боломжийг бүрдүүлсэн, ашиглахгүй бараа материалын үлдэгдлийг нэмэгдүүлсэн, орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийн өрсөлдөх боломжийг хязгаарласан байна.

Дээрх 1057,8 сая төгрөгийн зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, хэмжилт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүйгээс тус компаний санхүүгийн тайланд **“Сөрөг”** санал дүгнэлт өгсөн.

2. *Нийтлэг үйлчилгээний газар:* Тус байгууллага нь дор дурдсан үндэслэлээр төсөвт байгууллагад хамаарч байхад МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан УСНББОУСтандарт, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 7 тоот тушаалаар баталсан төсвийн ангилал, Сангийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 216 тоот тушаалаар баталсан журам, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 тоот тушаалаар баталсан зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаагүй байна. Үүнд:

- 2006 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 01 тоот шийдвэрээр бүртгүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээнд байгууллагын хариуцлагын хэлбэрийг төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж заасан.
- Дорноговь аймгийн Засаг даргын 2017 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн А/72 тоот захирамжийн 2 дугаар хавсралтаар баталсан “Нийтлэг үйлчилгээний газрын дүрэм”-ийн 1.1-т “Аймгийн Засаг даргын дэргэдэх Нийтлэг үйлчилгээний газар нь /цаашид “Газар” гэнэ/ аймгийн Засаг дарга түүний Тамгын газар болон төсвөөс санхүүждэг бусад байгууллага /цаашид “үйлчлүүлэгч” гэнэ/-ын хэвийн үйл ажиллагааг хангах нийтлэг үйлчилгээний талаар тогтоосон нэгдсэн бодлогыг хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий нутгийн захиргааны хэрэгжүүлэгч “Орон нутгийн төсөвт албан газар” мөн” гэж тодорхойлсон.
- Тус дүрмийн 1.3-т “Аймгийн Засаг дарга тус газрын бүтэц, орон тоо, дүрмийг батална” гэж заасан.

Гэтэл тус байгууллага нь дээрх дүрэм, журам зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргаагүй, аж ахуй нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийг үндэслэн санхүүгийн тайланг бэлтгэн гаргасан тул Нийтлэг үйлчилгээний газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд Сөрөг дүгнэлт өгсөн.

Аудитаар 17948,9 сая төгрөгийн 63 алдаа зөрчил илэрч, 0,8 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 14,8 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 5704,0 сая төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлж, нийт 12229,3 сая төгрөгийн 50 зөвлөмж хүргүүллээ.



2.4 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд төсвийн төвлөрүүлэн захирагч, орон нутгийн төсөвт болон тусгай шилжүүлгийн, ОНӨХХК, төсөл, сангуудын нийт 235 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. ТЭЗ-ийн тайланд дараах зөрчил илэрлээ.

- Засаг даргын нөөц хөрөнгөөс 60,3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн,
- Төсвийн тухай хуулийг зөрчин тухайн шатны төсөвт хамаарахгүй байгууллагад 102,0 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт олгосон,
- Төрийн сангийн үйл ажиллагаанд НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасан “мэдээлэл боловсруулах үйл ажиллагаа”-ны дагуу журнал хөтлөөгүй,
- Аймгийн ИТХурал, Замын-Үүд сумын ИТХ “орон нутгийн нөөц хөрөнгө” гэсэн зориулалтаар бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөр хураамж гэсэн зардлын ангилалд нийт 161.0 сая төгрөгийг батлуулж зарцуулсан
- Засаг даргын нөөц хөрөнгөөс 30 хувь буюу 240.0 сая төгрөгийг нөөц болгож үлдээлгүй тайлант онд зарцуулсан байна.

ТЭЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар 67973,2 сая төгрөгийн 38 алдаа зөрчил илэрч, 67710,2 сая төгрөгийн 21 алдааг залруулж, 263,0 сая төгрөгийн 4 зөвлөмжийг хүргүүлээ.

ТЭЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн аудитаар 62412,8 сая төгрөгийн орлого, 61943,1 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлийг баталгаажуулж, нийт 5 зөвлөмж хүргүүлсэн.

3 ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Төрийн аудитын газрын 2019 үйл ажиллагааны төлөвлөгөөнд эхний хагас жилийн байдлаар нийт 3 гүйцэтгэлийн аудит хийхээр тусгагдсан бөгөөд УАГ-ын нэгдсэн удирдамжаар 1 аудит, өөрсдийн санаачилгаар 3 аудит /өмнө онд эхлүүлсэн аудитыг үргэлжлүүлэн тайлант хугацаанд дуусгасан/-ыг хийж гүйцэтгэлээ.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 3082,4 сая төгрөгийн 20 зөрчил илрүүлж, 1680,7 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 1401,7 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж хүргүүлсэн.

Тайлант хугацаанд 5,5 сая төгрөгийн 4 албан шаардлага хэрэгжиж, 36,3 сая төгрөгийн зөвлөмж хэрэгжсэн байна.



3.1 “Аймгийн орон нутгийн төсвийн татварын бус орлого бүрдүүлэх үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит

Аймгийн Төрийн аудитын газрын санаачилгаар тус аудитыг 2018.11.19-2018.12.25 хүртэлх хугацаанд гүйцэтгэж, татварын бус орлого бүрдүүлэхэд байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хяналтыг сайжруулж, иргэдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлага байна гэсэн дүгнэлт өгсөн.

Аймгийн татварын бус орлогыг бүрдүүлэгч аймгийн ШШГГазар, Цагдаагийн газар, Замын-Үүд сумын ШШГХэсэг, Цагдаагийн хэлтэс, Хилийн мэргэжлийн хяналтын алба, аймгийн МХГ, Улсын бүртгэлийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар зэргийг хамруулан хүү торгууль, түрээсийн орлогын бүрдүүлэлтийг хамруулан аудитыг гүйцэтгэсэн ба татварын бус орлогын ихэнх төрлүүд нь тогтмол бус, тогтсон хувь хэмжээ байдаггүйгээс өнгөрсөн жилийн гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж иржээ.

Аудитаар бэлэн бусаар оногдуулсан зарим торгуулийн орлого болон түрээсийн орлогыг журмын дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, зөрчил гаргасан иргэд холбогдох журмын заалтыг мөрдөөгүйгээс бэлэн бус хэлбэрээр оногдуулсан торгуулийг тогтоосон хугацаанд барагдуулаагүй, эрүүгийн хэрэг болон торгох ялын 1493.7 сая төгрөгийн дүн бүхий шийдвэр хэрэгжээгүй, Мэргэжлийн хяналтын байгууллагаас оногдуулсан 7.2 сая төгрөгийн торгуулийг иргэн, хуулийн этгээдүүд барагдуулаагүй зэрэг нийт 316,8 сая төгрөгийн 7 зөрчил илрүүлж, 5,7 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 311,1 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн.

3.2 Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг /ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар/

Аудитыг ҮАГ-ын нэгдсэн удирдамж, ТАГ-ын 2019 оны төлөвлөгөөний дагуу 2019.01.01-2019.04.10-ны хугацаанд гүйцэтгэлээ. Тус аймагт 23.4 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр эрх шилжүүлэн, 4.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тайлант онд олгохоор шийдвэрлэсэн байна.

Аудитаар Орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний зураг төсвийг жагсаалт батлагдсаны дараа боловсруулж, баталгаажуулсан, их засварын ажлыг төлөвлөхдөө мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслээгүй, эрх шилжүүлсэн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хугацаа алдсан, тендерийн баримт бичгийг журмын дагуу боловсруулаагүй, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа холбогдох хуулийн заалтыг мөрдөж ажиллаагүй зэрэг зөрчил илрүллээ.

Мөн гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын ажлыг техникийн тодорхойлолт, гэрээний дагуу гүйцэтгээгүй байхад комисс хүлээн авсан, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй, хөрөнгө оруулалтаас бий болох үр ашгийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөж, бодит үр нөлөөг тооцоогүй байна.

Аудитаар нийт 1999,1 сая төгрөгийн 7 зөрчил илрүүлж, 1675,0 сая төгрөгийн 3 албан шаардлага, 324,1 сая төгрөгийн 4 зөвлөмж хүргүүллээ.

4 НИЙЦЛИЙН АУДИТ

Аймгийн Төрийн аудитын газрын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эхний хагас жилийн байдлаар нийт 3 нийцлийн аудит хийхээс ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 3 аудитыг гүйцэтгэлээ.

Нийцлийн аудитаар нийт 3662,9 сая төгрөгийн 40 зөрчил илрүүлж, 1,4 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт, 911,2 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 2750,3 сая төгрөгийн зөрчилд 23 зөвлөмж хүргүүлсэн.

Тайлант хугацаанд 450,9 сая төгрөгийн 17 зөвлөмж хэрэгжсэн байна.

4.1 “Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт” сэдэвт нийцлийн аудит

Аудитыг ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 2019 оны 03 сарын 01-ний өдрөөс 04 сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэж “Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтад холбогдох хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна” гэсэн дүгнэлт өглөө.

2018 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 1373.3 сая төгрөгийн 4 ТАХ, 14 суманд 1399.6 сая төгрөгийн төсөвт өртгөөр 87 ТАХ-г төлөвлөн, хэрэгжүүлсэн байх ба нийт ХАА-ны 7 хувийг НТШ, 29 хувийг ХА, 9 хувийг ОНО, 56 хувийг ШГ байгуулсан байна.

2018 онд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 2761.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 92 ТАХ хэрэгжүүлэхээр гэрээ байгуулснаас 2688.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 86 ТАХ бүрэн хэрэгжиж, 141.5 сая төгрөгийн төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 ТАХ дутуу хэрэгжсэн байна.

Аудитаар Сайншанд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ТАХ нь тухайн оны сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй, 2018 онд хэрэгжүүлсэн ТАХ-ны техникийн тодорхойлолтыг хангалтгүй боловсруулсан, сумдад хөрөнгө оруулалтын ажлуудад мэргэжлийн байгууллагын хяналт тавигдаагүй, захиалагчийн хяналт чанартай хийгдээгүй, хяналтыг тогтмол хэрэгжүүлээгүйгээс хөрөнгө оруулалтын ажлууд нь холбогдох норм дүрэм, чанарын баталгааг хангаагүй, барилга угсралт, засвар, гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, инженерийн хийцтэй болон гар худаг гаргах зэрэг ажлуудад ил, далд ажлын актыг үйлдээгүй, орон нутгийн хөгжлийн сангийн зааварт заасан чиг үүрэгт хамаарахгүй болон урсгал зардлын шинжтэй ТАХ-г хэрэгжүүлсэн, гүйцэтгэлийг бүрэн хянаагүйгээс санхүүжилтийг илүү олгож санхүүжүүлсэн, 111.6 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын өмчид бүртгээгүй байна. Мөн өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж бүрэн хэрэгжээгүй зэрэг зөрчил илэрлээ.

Аудитаар нийт 2928,5 сая төгрөгийн 15 зөрчил илрүүлж, 1,4 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт, 176,8 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн 2750,3 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүллээ.

4.2 “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудит

Тус аудитыг ЯАГ-ын нэгдсэн удирдамж, аймгийн ТАГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 2019.02.26-2019.04.01 хүртэлх хугацаанд гүйцэтгэж “Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна” гэсэн дүгнэлт өглөө. Аудитад улс, орон нутгийн төсвийн 173 байгууллагыг хамруулж, 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар хуулийн хэрэгжилтийг шалгалаа.

Аудитаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААНБ-ууд шилэн дансны нэгдсэн системд цахим хуудас нээлгээгүй, холбогдох мэдээллийг мэдээлээгүй, Замын-Үүд сумын Ухаалаг багачууд, Жаргалан, Гурван билэг, Болор-Эрдэнэ цэцэрлэгүүд, Үлэмж тэнгэр ерөнхий боловсролын сургууль, Сайншанд сумын Төмөр замын МСҮТ зэрэг аж ахуйн нэгж байгууллагууд шилэн дансны цахим хуудас хөтлөөгүй, мэдээлэл огт оруулаагүй, шилэн дансны нэгдсэн системд улс, орон нутгийн төсвийн байгууллагууд бүрэн хамрагдсан ч хуульд заасан мэдээллүүдийг бүрэн оруулах ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Аудитаар 642,6 сая төгрөгийн 5 зөрчил илрүүлж, 642,6 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага тогтоож, МУ-ын Сангийн яаманд шилэн дансны нэгдсэн системийг боловсронгуй бөгөөд энгийн болгох талаар саналыг уламжилж, аймгийн Засаг дарга, Сайншанд сумын Засаг даргад хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар 3 зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

4.3 “Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр үйл ажиллагаа нь газрын тухай хуульд нийцсэн эсэх” сэдэвт нийцлийн аудит

Аудитыг ЯАГ-ын нэгдсэн удирдамжаар 2019 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэж “Үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөө байхгүйгээс тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулахад хүндрэлтэй байна” гэсэн дүгнэлт өглөө.

2018 оны жилийн эцсийн байдлаар Дорноговь аймгийн хэмжээнд нийт газар нутгийн 78 хувийг эзэмшлээр, 22 хувийг ашиглалтаар, 0.004 хувийг өмчлөлөөр ашиглаж байна.

Аудитаар газар зохион байгуулалтын үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөө байхгүйгээс хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг цаашид хэрхэн баримталж, хэрэгжүүлэх нь тодорхойгүй, тухайн жилд төлөвлөсөн хэмжээнд газар олголт хийгдээгүй, 2015-2018 онд гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар газрыг олгохдоо тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгахгүйгээр өмнөх оны төлөвлөгөөг үндэслэн олгосон, зарим сумдад 2015-2016 онд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр 10.6 га газрыг шууд олгосон, Орон нутгийн тусгай хэрэгцээний газарт гэрээ байгуулан худалдаа үйлчилгээ эрхэлсэн, аймгийн хэмжээний 14 суманд 2018 оны жилийн эцсийн



байдлаар нийт 6093 иргэн, ААНБ нь 47.9 сая төгрөгийн газрын төлбөрийг төлөөгүй, иргэд гэр бүлийн хэрэгцээний газрынхаа тодорхой хэсгийг холбогдох шийдвэргүйгээр зориулалтыг өөрчлөн худалдаа, үйлчилгээ, бусад зориулалтаар ашигладаг, зарим сумдад 288 иргэн, ААНБ эзэмшлийн газраа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтаар 2 жил дараалан ашиглаагүй, газрыг хоосон хашаажуулсан, барилга дутуу барьж орхисон, Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаа зэрэг зөрчил илрүүлээ.

Аудитаар нийт 98.1 сая төгрөгийн 20 зөрчил илрүүлж, 91,8 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, зөрчил арилгуулахаар 13 зөвлөмжийг хүргүүллээ.

5 ИТХ-ЫН ЗАХИАЛГА, ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ

5.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудит

Аудитыг аймгийн ТАГ-ын санаачилгаар 2019.01.02-2019.04.10-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэж “Хөрөнгө оруулалтын төлөвлөлт хууль журмын дагуу хийгдээгүйгээс хэрэгжилт хангалтгүй байна” гэсэн дүгнэлт өглөө.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө Засаг даргын үйл ажиллагааны “**ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА**” 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймаг хөгжүүлэх хэтийн зорилт зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй, холбогдох байгууллагуудын санал дүгнэлтийг үндэслээгүй, хэрэгжиж дуусах хугацаа тодорхойгүй, төсөвт өртөг зөрүүтэй төсөл арга хэмжээнүүдийг оруулж батлуулсан байна.

Мөн хөрөнгө оруулалтын жагсаалт батлагдсаны дараа 3.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 төсөл, арга хэмжээний зураг төсвийг боловсруулж, хуульд заасан чиг үүрэгт хамаарахгүй, хөрөнгө оруулалтын бус зардлыг төлөвлөж батлуулсан байна.

Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын ажлыг техникийн тодорхойлолтын дагуу, гэрээний дагуу гүйцэтгэх үүргээ бүрэн биелүүлээгүй, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, магадлашгүй ажлыг хянан баталгаажуулахгүй санхүүжилтийг олгожээ.

Аудитаар нийт 766.5 сая төгрөгийн 6 зөрчил илрүүлж, 2 албан шаардлага, 4 зөвлөмж хүргүүллээ.

5.2 Орон нутгийн өмчит компаниудын худалдан авах ажиллагааны үр дүн гүйцэтгэлийн аудит

Тус аудитад орон нутгийн өмчит болон ААТҮГ гэсэн 6 байгууллага хамрагдаж байгаа бөгөөд төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн үе шатны ажлыг хэрэгжүүлж байна

6 ДОТООД АЖИЛ

6.1 Дотоод сургалт

Монгол улсын Ерөнхий аудитор 2019 оныг “Аудитыг баримтжуулах бодлого, арга зүйг боловсронгуй болгож төлөвшүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан дотоод сургалтын төлөвлөгөө боловсруулан нийт 11 сургалт зохион байгуулахаар төлөвлөн, эхний хагас жилийн байдлаар дотооддоо 4 чиглэлээр сургалтыг зохион байгуулаад байна.

Гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Ц.Лүндэгмаа “СТА-ыг хийхэд анхаарах асуудал” сэдэвт дотоод сургалтыг 2019.01.07-ны өдөр, 2019.06.18-ны өдөр аудитор Т.Мөнхтогтох “Дотоод удирдлагын программ хангамжийг хэрэглэх нь”, аудитор Б.Уранбилэг “Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар нийт ажиллагсад сургалт зохион байгуулах”, нийцлийн аудитын ахлах аудитор Э.Энхцэцэг “Төрийн архив, албан хэрэг хөтлөлт” сэдвээр тус тус дотоод сургалтыг зохион байгуулж, аудиторуудыг ажлын байранд чадваржуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Аймгийн Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны сургалтад салбарын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдал, шалтаан, үр дагаврын талаар аудитор У.Оюунтүлхүүр мэдээлэл хийв.

6.2 Бусад байгууллагаас авах сургалт

- ЯАГ-аас 2019.01 дүгээр сард зохион байгуулсан “Удирдах ажилтны зөвлөгөөн”-д тэргүүлэх аудитор Ч.Ариунаа;
- ЯАГ-аас зохион байгуулсан “Архив, дотоод ажил хариуцсан ажилтнуудын сургалт”, 2019.02.18-20-ны өдрүүдэд “Төрийн аудитын газрын харьяа төсвийн шууд захирагчдын нягтлан бодогчдын сургалт”-д нягтлан бодогч Б.Мөнгөнцэцэг;



- 2019.05.23-05.24-ний өдрүүдэд ЯАГ-аас зохион байгуулсан “Төрийн аудитын байгууллагын мэдээллийн технологийн ажилтнуудад зориулсан дотоод удирдлагын программ хангамжийн сургалт”-д аудитор Т.Мөнхтогтох;



- Дорноговь аймагт 2019 оныг “Гэр бүлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан аймгийн ГБХЗХГазраас зохион байгуулсан “Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо”, “Гэр бүл төлөвлөлт, харилцаа хандлага” сэдэвт 2 удаагийн сургалтад ахлах аудитор О.Нарангарав, аудитор У.Оюунтүлхүүр нар;
- Архивын улсын үзлэг зохион байгуулахтай холбогдуулан аймгийн Архивын тасгаас зохион байгуулсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлт”-ийн сургалтад бичиг хэргийн ажилтан Б.Мөнгөнцэцэг;
- Аймгийн Статистикийн хэлтсээс 2019.06.15-д зохион байгуулсан “Статистикийн мэдээллийг ашиглах нь” сургалтад ахлах аудитор Э.Энхцэцэг;
- МУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад тэргүүлэх аудитор Ч.Ариунаа;
- Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөлт” сургалтад аудиторууд хамрагдсан болно.

6.3 Архив, бичиг хэрэг

МУ-ын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамжийн дагуу архивын улсын үзлэг зохион байгуулагдахтай холбогдуулан дарга, тэргүүлэх аудиторуудын 2019 оны А/13 тоот тушаалаар 8 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилсон.

Тус комисс нь 17 зүйл заалт бүхий ажлын төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2003-2018 онуудын архивын баримтыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байнга, 70 жил, түр хадгалах нэгжээр нягтлан шалгаж, бүрдэл болгосон, мөн архивын өрөөг холбогдох стандартад нийцүүлэн засварлаж, 2,8 сая төгрөгийг зарцууллаа.

Аймгийн салбар комиссын урьдчилсан үзлэгт хамрагдаж “Хангалттай” үнэлэгдлээ.

6.4 Ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа

Ажилчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор ажлын байрны дасгалыг өдөр бүр хийж хэвшүүлсэн. Мөн 7 хоног бүрийн даваа гарагт спорт зааланд сагсан бөмбөг, гар бөмбөгөөр хичээллэх, ажлын байран дээр ширээний теннисний ширээ байрлуулж, ажилчдын спортоор хичээллэх нөхцөл боломжийг ханган ажиллаж байна.

6.5 Дотоод зохион байгуулалтын бусад асуудал

- Байгууллагын эцэг эхийн зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилон, 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталлаа.
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2019 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталж, нийт 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.
- УАГ-ын audit.mn цахим хуудаст аудитын тайлан, байгууллагын мэдээллийн самбарт санхүүгийн аудит, гүйцэтгэл, нийцлийн аудитын албаны тайлант онд хийсэн аудитын талаарх товч мэдээллийг байршуулж, мэдээллийн санг тогмол шинэчлэн ажиллаж байна.

7 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журмын дагуу хөтөлж, 2019 оноос НББ-ийн үйл ажиллагаанд “Unicus” программыг ашиглаж байна.

Тайлант онд 273,1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас эхний хагас жилийн байдлаар 153,5 сая төгрөгийн санхүүжилт авч, 104,3 сая төгрөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.

Хэмнэгдсэн зардлыг авч үзвэл оны эхнээс 2-3 орон тоо дутуу ажилласнаас цалин, НДШ-ийн зардал 38,0 сая төгрөг хэмнэгдэж байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аудитын үйлчилгээний төлбөрт нийт 54,2 сая төгрөг төвлөрч, ХАК-иудад 40,4 сая төгрөг олгоод байна. Төрийн аудитын байгууллагын аудитуудын гүйцэтгэсэн аудитын үйлчилгээний төлбөрөөс төвлөрүүлсэн 12,8 сая төгрөгийг байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулан зарцуулах саналыг ҮАГ-т хүргүүлээд байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, татвар, НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн бөгөөд, 2020 оны төсвийн төслийг ҮАГ-т хүргүүлээд байна.

Мэдээллийн ил тод байдлыг хангаж шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд тогтмол байршуулан, илгээж байна.

8 ДҮГНЭЛТ, САНАЛ

8.1 Дүгнэлт

2019 оны эхний хагас жилийн байдлаар санхүүгийн тайлангийн 217 аудит, ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 1 гүйцэтгэлийн аудит, 3 нийцлийн аудит, өөрсдийн санаачилгаар 2 гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэлээ.

Аудитаар нийт 108498,2 сая төгрөгийн 626 алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 72403,6 сая төгрөгийн 120 алдааг залруулж, 167,61 сая төгрөгийн зөрчилд 71 төлбөрийн акт тогтоож, 9360,64 сая төгрөгийн зөрчилд 83 албан шаардлага хүргүүлж, 26547,94 сая төгрөгийн зөрчилд 338 зөвлөмж, 18,4 сая төгрөгийн зөрчилд 13 хариуцлага тооцох санал хүргүүлж, 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.



8.2 Санал

1. МУ-ын Ерөнхий аудиторын 2018 оны А/235 дугаар тушаалаар төрийн аудитын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулах, тайлагнах журам шинэчлэгдэн батлагдсан. Тус журмаар бүртгэл, нэгтгэл, статистикийн мэдээний нийт 30 маягтыг хөтлөх болсон нь хэт ачаалал үүсгэж байгаа учир статистик мэдээний нэгдсэн программ хангамжтай болгох саналыг уламжилж байна.
2. Манай байгууллага нь Орон нутгийн өмчийн байранд нийт 12 жил үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Энэ хугацаанд тус байранд засварын ажил хийгдэж байгаагүй бөгөөд одоогоор дээврээс борооны ус гоожиж дотор засал, өнгө үзэмж алдагдаад байна. Иймд байрны дээврийн болон дотоод засалд шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж өгнө үү.
3. Тус байгууллагын ажиллагсад 2015 оноос хойш гадаад сургалтад хамрагдаагүй тул орон нутаг дахь Төрийн аудитын газрын албан хаагчдыг гадаадын сургалтад хамруулж, чадавхжуулах талаар дэмжиж ажиллана уу.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА